



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 5/10

Мөрөн сум

Г.Дашмаад Зэрэг дэвийн
нэмэгдэл олгох тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 56 тоот, Аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/106 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/106 тоот захирамжаар Сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа)-д Албан тушаалын зэрэг дэвийн Дэс түшмэлийн гутгаар зэрэг дэвшүүлэн олгосон тул зэрэг дэвийн нэмэгдлийг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.

2. Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа)-д албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын цалингаас 20 хувиар тооцож, сар тутам олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Т.Баяртуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Ц.Болорцэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ